



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/56

Мандалговь

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ой угтаж аймгийн төвийн байгаль орчны бохирдол, өнгө үзэмжид нөлөөлж байгаа хуучин барилгуудыг засварлуулах, шаардлага хангахгүй болсон барилгыг буулгуулах, барилгын хуучин хогийг цэвэрлүүлж хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: М.Анхбаяр (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Н.Эрдэнэ-Очир (Аймгийн Засаг даргын Тамгын

газрын Хөрөнгө оруулалт,
хөгжлийн бодлого төлөвлөлтийн
хэлтсийн дарга)

Э.Чагнаадорж (Аймгийн Газрын харилцаа,
барилга, хот байгуулалтын газрын
дарга)

Ш.Төрбат (Аймгийн Мэргэжлийн хяналтын
газрын дарга)

Н.Гантулга (Аймгийн Байгаль орчин аялал
жуулчлалын газрын дарга)

С.Бат-Оргил (Сайнцагаан сумын Засаг дарга)

Х.Анхбаяр (Сайнцагаан сумын Хот
тохижуулах газрын дарга)

2. Хуучин барилга байгууламжийг засварлуулах, шаардлага хангахгүй болсон барилгыг буулгуулах, барилгын хуучин хогийг цэвэрлүүлэх талаар холбогдох аж ахуйн нэгж, иргэдтэй уулзан хугацаатай мэдэгдлийг хүргүүлэн шийдвэрлэж тухай бүр Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан ажиллахыг ажлын хэсэг (М.Анхбаяр)-т даалгасугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумдын өнгө үзэмжийг сайжруулах, ашиглалтгүй байгаа барилга байгууламжийг цаашид ашиглах эсэх талаар шийдвэрлэж тодорхой арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.МӨНХБАТ

481210137